



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 9/35

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга (Ховд, Жаргалант сум, 12-р баг, Малчны хороолол)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг дарга

Гишүүдэд: Б.Энхцоож - Боловсролын газрын мэргэжилтэн

Б.Энхболд - Төрийн бус байгууллагын төлөөлөл

М.Энхболд - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Э.Цолмон - Худалдан авах ажиллагааны албаны
мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Ц.Цогтбаяр)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Цолмон)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

.. 8400 03.01.3
D/Tush-A/35-Bo